



АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН
САЛБАР

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН | 2024

ЭМГ-УТСХ-ИЙН
ДАРГА Б.ГАНШАГАЙ

Эрүүл мэндийн
салбарын хүний нөөц


2024.05.02-03




Эрүүл мэндийн салбарын статистик мэдээгээр:

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД 4500 ГАРУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТ
56 МЯНГА ГАРУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНУУД, 14 МЯНГА ОРЧИМ ИХ ЭМЧ



■ эм ■ эр



■ УБ
■ Орон нутаг

МОНГОЛ УЛСЫН
САНДЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАР




Умнугуйн нутагны эрүүл мэндийн газар

Эрүүл мэндийн салбарын статистик мэдээгээр:

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Эмнэлгийн төрлөөр





Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллага, хүний нөөц

№	Байгууллагууд	Тоо	Ажиллагсад
1	Эрүүл мэндийн газар	1	36
2	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	1	245
3	ЗӨСТөв	1	12
4	Сумын ЭМТөв	14	341
6	Өрхийн ЭМТөв	3	56
7	Эмийн сан	61	150
8	Эм ханган нийлүүлэх байгууллага	5	18
9	Хувийн эмнэлэг	45	191
10	Цэргийн ангийн эмнэлэг	3	27
11	Нийт	134	1076




Улаанбаатарын эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн зарим үзүүлэлтүүд

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН 134 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН 1076 ЭМЧ,
ЭМНЭЛГИЙН АЖИЛЧИД АЖИЛЛАЖ БАЙНА.






УМНУГОВИЙН ЭРЭМ ХАМГААЛАХ ХЭВЧИЛЭГ


Нийт ажиллагсдыг албан тушаалаар нь харьцуулахад:

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024





Нийт ажиллагсдыг насны ангилалаар нь харьцуулахад:






Улаанбаатарын
Сүхбаатар
Засаг Засаг
Дарга

Эрүүл мэндийн ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөн


УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Шинээр нэмэгдсэн ажиллах хүчний тоо (2023 он)





Эрүүл мэндийн ажиллагчид 10,000 хүн амд, аймгаар 2023 он






УМНОГОВИЙН ЭМНЭГЭВЭР

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад 10,000 хүн амд улс, аймгийн түвшинтэй харьцуулвал






Умнговь аймаг
сүх дэвсгэр
сүх дэвсгэр

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Их эмч 10,000 хүн амд






УМНОГОВЫ АЙМАГЫН ЭРЭМШЭЛЭМЭДНИЙ ХАМГААГАХ ХЭВЧИЛЭГ

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Сувилагч 10,000 хүн амд





Улаанбаатарын
Салбарын
Хүний Нөөц

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024




Стандарт хангалт:

БОЭТ-69,4

СЭМТ-89

ӨЭМТ-98,2

ДУТАГДАЛТАЙ ЭМЧ, СУВИЛАГЧ



81 ЭМЧ
СУВИЛАГЧ

2023 ОНД ШИНЭЭР НЭМЭГДСЭН
ЭМЧ, СУВИЛАГЧ



Умнговь аймгийн
СЭМТ-ийн
байгууллагын
сүл орон тооны
мэдээлэл

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН СУЛ ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ																											
ӨМНӨГОВЬ АЙМАГ																											
2024.03.15																											
№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Их эмч	Багийн эмч	Гэмтлийн эмч	Яаралтай тусламжийн эмч	Мэс заслын эмч	Дүрс оношилгооны эмч	Уламжлалтын эмч	эх барих эмэгтэйчүүдийн эмч	Лабораторын эмч	Эмгэг судлаач эмч	Шүдний эмч	Хавдрын эмч	Өсвөр үеийн эмч	Халдвар судлаач	Дүн Бүртгэгч	Рентген техникч	НЭМАжилтан	Лаборант	Сувилагч	Эх баригч	эм найруулагч	Эм зүйч	Бусад	Нийт	Тайлбар	
1	Баяндалай СЭМТ	2	3																1	1	1				8	Сул орон тоо байхгүй	
2	Баян-Овоо СЭМТ																								0		
3	Булган СЭМТ	2																	1	4					7		
4	Гурвантэс СЭМТ	4																							4		
5	Мандал-Овоо СЭМТ		2																1						3		
6	Манлай СЭМТ	2																	1						3		
7	Номгон СЭМТ		3																						3		
8	Ноён СЭМТ																	1		1					2		
9	Сэврэй СЭМТ	1																	1						2		
10	Ханбогд СЭМТ						1																	1	2		
11	Ханхонгор СЭМТ		1																						1		
12	Хүрмэн СЭМТ		1													1		1							3		
13	Цогт-Овоо СЭМТ	2																							2		
14	Цогтцэций СЭМТ								1																1		
15	Шимбилэг ӨЭМТ																								0	Сул орон тоо байхгүй	
16	Өнө-Орших ӨЭМТ															1		1							2		
17	Энхийн хүслэн ӨЭМТ																								0	Сул орон тоо байхгүй	
18	БОЭТ				3	1			2		1				1					10				2	20		
		13	10	0	3	1	1	0	3	0	1	0	0	0	1	2	0	3	5	16	1	0	0	3	63		



Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарт нэн тулгамдаж буй хүний нөөц





Улаанбаатарын
Сүхбаатар
Засагд



3Курим шөнөчлөн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дүгээр зүйлийн 10, 3.3 дүгээр зүйлийн 1, 2 дүгээр хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дүгээр зүйлийн 25.9, 25.13, 26.15 дахь хэсгийг тус тус үлчилсэн ТУШААХ нь:


1. "Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцож, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, чөлөө олгох журам"-ыг нэгдүгээр, "Гадаадын амьтлын мэргэжилтэнд зөвшөөрөл олгох журам"-ыг хоёрдугаар, "Зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг"-ийг гуравдугаар, "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний заавар"-ыг дөрөвдүгээр, Төгрөгдүн эмнэлгийн мэргэжилтний танилцууллын маягт"-ыг талдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Амьтлын мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 2.2, 2.5-2.9, Талдугаар бүлгийн 5.1, 5.2 дүгээр зүйл, 5.3 дүгээр зүйлийн 2, 3, 8, 9 дэх хэсэг, 5.4, 5.5 дүгээр зүйл, Зургадугаар бүлгийн 6.1, 6.2, 6.3 дүгээр зүйлд заасныг зохицуулах эрхэйг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д шилжүүлэн олгосугай.

3. Тушаалыг нийт эрүүл мэндийн байгууллагад сурталчлан таниулах, хэрэгжилтэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажиллахыг Бодлого, төлөвлөлийн газар /П.Оюундэлгэр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлэх ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д нэгдсэн удирдлагаар хянаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Боданзүлжиг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-дэмжлэгийн, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус зүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалыг зурчигуур болгонд тооцсугай.



УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛНЭ:

- Зөвшөөрлийн шалгалт, багц цаг бүрдүүлэхтэй холбоотой мэдээллээр эмнэлгийн мэргэжилтэнг хангах, төгсөлтийн дараах багц цагийн богино хугацааны сургалтыг орон нутгийн түвшинд мэргэжлийн нийгэмлэг, холбоотой хамтран зохион байгуулах;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд тогтмол баяжуулалт хийх, харьяалах эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн нэгтгэлийг орон нутгийн түвшинд улирал тутам гаргаж дүгнэх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

- Хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эмнэлгийн мэргэжилтэнг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрөл олгосон төрлөөр томилон ажиллуулах;
- Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд эмнэлгийн мэргэжилтэн тус бүрийн зөвшөөрөл, сургалт, ажлын байр, оршин суух хаяг, бусад мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр бүртгэх;
- Зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах, эмнэлгийн мэргэжилтэн багц цаг бүрдүүлэх, төгсөлтийн дараах сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх;
- Зөвшөөрөл сунгуулах эмнэлгийн мэргэжилтний судалгааг улирал тутам гаргаж, зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос ажлын 50-аас доошгүй хоногийн өмнө эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргах талаар сануулж мэдэгдэх;
- Зөвшөөрлийн шалгалтад орох эмнэлгийн мэргэжилтний үүрэгт ажлыг зохицуулах, дэмжлэг үзүүлэх.



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

- Хүчин төгөлдөр зөвшөөрлийн гэрчилгээтэй ажиллах, зөвшөөрлийн гэрчилгээг гээгдүүлж үрэгдүүлэхгүй хадгалах;
- Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн зөвшөөрөл олгосон төрлөөр тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу багц цагийг жил тутам бүрдүүлж, тооцуулах, 5 жил тутам зөвшөөрлөө сунгуулах
- Зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болохоос ажлын 30- аас доошгүй хоногийн өмнө зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар гаргах;
- Зөвшөөрлийн шалгалтад орох тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зарласан бүртгэлийн хугацаанд багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар хүсэлт гаргах, хугацаанд нь шалгалт өгөх
- Зөвшөөрөл анх удаа авах төгсөгчийн хувьд диплом гардан авснаас хойш ажлын 5 хоногт багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд хүсэлт гаргаж, бүртгүүлэх;



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

- Зөвшөөрлийн шалгалтад тэнцэж зөвшөөрөл авах эрх үүссэн тохиолдолд шалгалтын дүн гарсанаас хойш ажлын 10 хоногт багтаан эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд хүсэлт илгээж, баталгаажуулах
- Зөвшөөрлийн шалгалт, зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдон гарах зардлыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүдийн хамтран баталсан төлбөрийн жишгийн дагуу өөрөө хариуцан төлөх;
- Зөвшөөрөлтэй холбоотой санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, зөвшөөрлийн лавлагаа, тодорхойлолтыг цахим эсхүл цаасан хэлбэрээр монгол, англи хэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргуулж авах;
- Ажлын газар, оршин суух хаяг өөрчлөгдөх бүрт эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгүүлж, баталгаажуулах, өнгөт цээж зураг жил тутам шинэчилж оруулах.



Багц цаг тооцох

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

- Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, шүдний их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, эм найруулагч, сувилагч, бага эмч, эх баригч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн жил тутам 3 багц цаг бүрдүүлж, тооцуулна.
- Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт заасны дагуу багц цагаа бүрдүүлж ажилласан эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгана.
- Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, тухайн мэргэжлээрээ 30 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, ажлын тайланг үндэслэн зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгана.
- Эмнэлгийн мэргэжилтний жил тутам бүрдүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь ажиллаж байгаа мэргэжил, мэргэшлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвар хамгааллын чиглэлээр байна.

МОНГОЛ УЛСЫН
САНДОО
ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ
ЗӨВЛӨГӨӨН



Багц цаг тооцох

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

- Эмнэлгийн мэргэжилтэн бүр эмнэлгийн яаралтай тусламжийн багц цагийн богино хугацааны сургалт (амилуулах суурь тусламж, амилуулах лавшруулсан тусламж, гэмтэгсдийг аврах тусламжийн аль нэг)-д 2 жил тутам, халдвар хамгааллын багц цагийн богино хугацааны сургалтад 3 жил тутам, ёс зүй, хууль эрх зүйн багц цагийн богино хугацааны сургалтад 5 жил тутам суралцаж мэдлэг, ур чадвараа бататгаж, ахиулна.
- Сургалтын 8 цагийн хичээлийг 1 багц цагт тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байх ба аудио, видео хичээлийн үргэлжлэх хугацаа 30 минут байна.
- Багц цагийг сургалт болон сургалтын бус хэлбэрээр бүрдүүлж болно. Сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болох ба танхимын бус сургалтыг зайны (вэбинар), аудио, видео хичээл хэлбэрээр явуулна. Танхимын бус сургалтаар хангах багц цаг нь тухайн жилд бүрдүүлэх нийт багц цагийн 50 хувиас хэтрэхгүй байна.
- Эмнэлгийн мэргэжилтний тухайн жилд бүрдүүлсэн багц цаг нь энэхүү журмын 4.1-т зааснаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.



**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН ДОР ДУРДСАН ҮНДЭСЛЭЛИЙГ АЛБАН ЁСНЫ БИЧИГ
БАРИМТААР НОТОЛСОН ТОХИОЛДОЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН
ХУГАЦААНД ОРУУЛАН ТООЦОЖ, ТУХАЙН ХУГАЦААНД БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛЭХЭЭС
ЧӨЛӨӨЛНӨ:**

- **Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;**
- **Цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон;**
- **Өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувилуулсан;**
- **Донорын үүрэг гүйцэтгэсэн.**



Улаанбаатар
Засаг Засаг
Сүм

Зөвшөөрлийн гэрчилгээ олгох, НӨХӨН ОЛГОХ

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

- Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт заасанчлан эмнэлгийн мэргэжилтэнд 3 ба 5 жилийн хугацаагаар зөвшөөрөл олгоно.
- Зөвшөөрөл олгосныг нотлох баримт нь зөвшөөрлийн гэрчилгээ байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсэгт заасны дагуу эмнэлгийн мэргэжилтэн бүр зөвшөөрлийн давтагдашгүй дугаар бүхий зөвшөөрлийн гэрчилгээтэй байх ба давтагдашгүй дугаар нь боловсролын стандартын ангилал, индексийг багтаасан 8 орон тоо бүхий тэмдэгт байна.
- Эрүүл мэндийн хөгжлийн төв нь зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлэх ба шийдвэрийн төслийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- Энэхүү журмын 5.3-т заасан шийдвэрийн төслийг үндэслэн Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.5-25.7-д заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгоно
- Энэхүү журмын 5.4-т заасан шийдвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын гарын үсэг, тамга бүхий зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгоно.



УЛААНБААТАРЫН ЭРЭМТЭЙЛЭГ

УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨГӨӨН 2024

Зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох

- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эсхүл эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд эсхүл эмнэлгийн мэргэжилтэд зөвшөөрлийн гэрчилгээг албан ёсоор хүлээлгэн өгч, энэ тухай тэмдэглэл үйлдэж баримтжуулна.
- Зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн авах хүсэлтэй эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд цахимаар хүсэлт гаргана. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох үндэслэлтэй (зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй, багц цаг бүрдүүлсэн) гэж үзвэл зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсаар нийтэд зарлана.
- Зөвшөөрлийн гэрчилгээг тухайн зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд зөвхөн нэг удаа нөхөн олгох бөгөөд шинээр олгох зөвшөөрлийн гэрчилгээн дээр “нөхөн олгов” гэж тэмдэглэнэ.
- Эмнэлгийн мэргэжилтний үндсэн, төрөлжсөн мэргэшлээр ажиллах баталгаа нь тухайн мэргэшлийн сургалтад суралцсаныг нотлох мэргэшлийн үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг байна.
- Зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түтгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.



Анхаарал хандуулсанд баярлалаа

Улаанбаатарын эрэм хамгаалах хэвчилгээ